



ASIAN HEALTH SERVICES

101 8TH STREET, SUITE 100
OAKLAND, CA 94607

NON-PROFIT
ORG. US
POSTAGE PAID
OAKLAND, CA
PERMIT NO.
3630

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИАЛ БОЛОН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН



захигал 2024 он

Түүхт 50 жилийн үйл ажиллагаа болон амжилт ололтоо тэмдэглэж буй учир энэ нь Азийн Эрүүл Мэндийн Үйлчилгээний (AHS) хувьд түүхэн жил юм. Өнгөрсөн таван жил цар тахал гэх мэт сорилт бэрхшээлээс эхлээд Хямд тусламж үйлчилгээний тухай хууль, эмнэлэг, шүд, зан үйлийн эрүүл мэндийн үйлчилгээн дэх бидний ялалт, ололт амжилт зэрэг мартагдашгүй мөчөөр дүүрэн байлаа. Эдгээрийн туршид AHS-н зүгээс үйлчлүүлэгчид болон иргэдээ байнга анхаарлын төвдөө байлгаж ирсэн. Ирэх 50 болон түүнээс ч олон жил биднийг хүлээж байгаа тул 500 гаруй үйлчилгээ үзүүлэгч, ажилтнууд болон Удирдах зөвлөлийн гишүүд, олон нийтийн дэмжигчдээс бүрдсэн чадварлаг багтай болсондоо бид үнэхээр баяртай байна.

2024 он бол бидний ирээдүйг тодорхойлох чухал жил юм. Олон зүйл эрсдэлтэй байгаа учир сонгуулийн эрх бүхий бүх иргэдэд саналаа өгөхийг уриалж байна. Өөрийнхөө, гэр бүлийнхээ, нийгмийнхээ эрүүл мэнд, сайн сайхны төлөө саналаа

өгөөрэй. Саналын хуудсан дахь нэг чухал асуудал бол эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагууд (AHS гэх мэт) болон эмч нарын албуудыг нээлттэй байлгахад дөхөм болох Меди-Кал-т хамрагддаг 15 сая Калифорнийн иргэдэд үзүүлэх тусламжийг дэмжих тусгай санхүүжилтийг баталгаажуулах Prop 35 юм. Энэ нь таны татварыг нэмэгдүүлэхгүйгээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд зайлшгүй шаардлагатай санхүүжилт билээ. Калифорнийн иргэдийг эрүүл байлгахын төлөө энэ 11-р сард Prop 35-д саналаа өгөхийг бид та бүхэнд уриалж байна. Уг саналын хуудсанд өөр олон асуудал бий. Үүнд орон нутаг, муж, улсын хэмжээнд ирээдүйн удирдагчдаа сонгох явдал орно. Сонголтоо хийхэд тань туслах нэмэлт мэдээлэл өгөхийн тулд бид сонгогчдын гарын авлагыг олон хэл дээр орчуулан та бүхэнд хүргэх болно. Ямар ч асуудал сонгосон та бүхэн, саналаа заавал өгөөрэй!

Бид үйлчлүүлэгчдийн нэгдсэн хурлаа энэ

оны 10-р сарын 30-нд Окланд хотод дахин хийхээр төлөвлөөд байна! Энэхүү чухал хурлаар бид AHS-н үйлчлүүлэгчидтэй холбогдох, хийж буй ажлаа тайлагнах, та бүхний санал бодлыг шууд сонсох боломжтой болох юм. Түүнчлэн удахгүй хийгдэх нэмэлт ажлуудын талаарх сонирхолтой мэдээллийг та бүхэнтэй хуваалцах юм. Та манай нэгдсэн хуралдаанд хэрхэн оролцох талаарх дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцана уу.

Бид өнгөрсөн 50 жилийн хугацаанд та бүхэнд үйлчилж ирсэндаа талархалтай ханддаг бөгөөд цаашид ч олон жил хамтран ажиллахдаа баяртай байх болно. Бидэнд эрүүл мэнд болон бусад олон зүйлээ даатгадаг та бүхэнд талархлаа илэрхийлье.

Жулиа Лью, Гүйцэтгэх захирал, MPH



Ту Квок, Ерөнхийлөгч, PhD

Өвчтөний үзлэгийн дараах судалгаа

AHS "Өвчтөний үзлэгийн дараах судалгаа"-г эхлүүлээ! Энэхүү санал асуулга нь таны айлчлалаас шууд сэтгэгдэл, туршлагыг олж авах зорилготой зургаан богино асуултаас бүрдэнэ. Бидний үйлчилгээг сайжруулах, хамгийн сайн тусламж үйлчилгээг үзүүлэхэд таны санал хүсэлт үнэлж баршгүй юм. Явахаасаа өмнө цаг гарган судалгаагаа бөглөнө үү.



ASIAN HEALTH SERVICES

After Visit feedback

Site: _____
Date of Visit: _____



	Poor	Fair	Good	Great
1. Please rate your overall satisfaction with your visit today.	1	2	3	4
Please share any comments about your visit – was there anything that we did well or could improve?				



2024 ОНЫ НАМАР МЭДЭЭЛЛИЙН ТОВХИМОЛ

50 YEARS
ASIAN HEALTH SERVICES
1974 · 2024


Азийн Эрүүл Мэндийн Үйлчилгээний ACCESS нь хэвлэл мэдээллийн кампанит ажилд идэвхтэй оролцож, ард иргэдтэй тулж ажиллах замаар тэдний цогц сайн сайхан байдлыг дэмжих зорилготой. Түүнчлэн 510-735-3939 утсаар сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөгөө өгдөг. Манай зүгээс баримталдаг эрүүл мэндийн цогц арга барилд өөртөө анхаарал тавих, бусадтай холбоотой байх, сэтгэцийн эрүүл мэнд зэрэг амин чухал харилцан уялдаатай байдал ордог бөгөөд эдгээр гурван элемент нь иргэдийн ерөнхий эрүүл мэндэд маш чухал хэмээн үздэг билээ.

Энд бүх мэдээдэл бий. Үүнд AHS ACCESS-ийн тайлбар, YouTube-ийн видео холбоосууд, Linktree зэрэг орно. Хэрвээ танд бидний зүгээс өөр зүйл хэрэгтэй бол мэдэгдэнэ үү.

Linktree: linktr.ee/ahsaccess

Доорх QR кодыг сканнердаж манай 3 хэрэгтэй видеог үзэх боломжтой (англи, мандарин, кантон, вьетнам хэл дээр):

- Өөртөө анхаарал тавих:** Өөрийгөө тайвшруулах арга – Хейвнинг арга
- Харилцаа:** Нийгмийн талаарх өөрийгөө төсөөллөөр дамжуулан
- Сэтгэцийн эрүүл мэнд:** Сэтгэцийн эрүүл мэндийн хэрэгцээг анхааруулах шинж тэмдэг



2024 Томуугийн эсрэг эмнэлгүүд

510-986-6828 утсаар цаг товлох эсвэл доорх QR кодыг уншина уу



Насанд хүрэгчдийн томуугийн вакцины байршил, цаг*
19-өөс дээш настай, жирэмсэн байх боломжгүй.
Гишүүнчлэлийн үнэмлэх, цээж зурагтайгаа ирнэ үү.

Хүүхдийн томуугийн вакцины байршил, цаг*
ЗӨВХӨН Азийн Эрүүл Мэндийн Үйлчилгээний 6-18 насны өвчтөнүүд. Эцэг эх/хууль ёсны асран хамгаалагчийн хамт. Хүүхдийн AHS гишүүнчлэлийн карт, даатгалын картыг авч ирнэ үү.

Frank Kiang Medical Center (QR code #1)

250 E 18th Street, Oakland, CA
10/12/24 & 11/16/24 (бямба гариг: 9AM-1PM)



Rolland & Kathryn Lowe Medical Center (QR code #2)

835 Webster Street, Oakland, CA
10/19/24 & 11/2/24 (бямба гариг: 9AM-1PM)



Chenming & Margaret Hu Medical Center (QR code #3)

818 Webster Street, 3rd Floor, Oakland, CA
12/07/24 (бямба гариг 9AM-1PM)



Asian Resource Center

317 9th Street, Suite 101, Oakland, CA
12/10/24 & 12/17/24 (мягмар: 9AM-12PM)

Chenming & Margaret Hu Medical Center (QR code #A)

818 Webster Street, 3rd Floor, Oakland, CA
10/26/2024 & 11/09/2024, 12/07/2024
(бямба гариг: 9AM-1PM)



Дараах шинж тэмдгүүдийн аль нэг нь байгаа өвчтөнүүд ханиадны эсрэг вакцин хийлгэхээс өмнө эмчтэйгээ зөвлөлдөх хэрэгтэй.

Халуурах/жихүүдэс хүрэх, ханиалгах, хоолой өвдөх, амьсгалахад хэцүү болох, шинэ булчин, бүх биеэр өвдөх, амт/үнэр алдах, хамар битүүрэх, гоожих, дотор муухайрах/бөөлжих, суулгах



Эмнэлгийн огноо/цаг нь томуугийн вакцин байгаа эсэхээс хамаарч цуцлагдана. Баярлалаа.

Үйлчлүүлэгчийн хувийн нууцыг хамгаалах



Таны нэр, төрсөн огноо, утасны дугаар гэх мэт хувийн эрүүл мэндийн мэдээллийг хамгаалах нь Азийн Эрүүл мэндийн Үйлчилгээний хамт олон бидний хувьд тунчухал юм! Манайд ирэх үеэр тань тусламж, үйлчилгээ үзүүлж буй өөр өөр ажилтнууд хувийн мэдээлэл (өөрөөр хэлбэл нэр, төрсөн огноо, утасны дугаар)-ээ баталгаажуулахыг хүсч болно. Энэ нь таны хувийн нууцыг хамгаалах, баримт бичгийг зөв хүн (жишээ нь захидал, лаборатори, лавлагаа, лабораторийн үр дүн гэх мэт) хүлээн авч байгаа эсэхийг баталгаажуулах сайн арга юм. Энэ нь олон удаа давтагдаж байгаа мэт санагдаж болох ч таны хувийн мэдээллийг зөвхөн өөртэй тань хуваалцах замаар хувийн нууцыг тань хамгаалах зорилгоор хийгддэгийг анхаарна уу.

Ухаалаг утсаа ашиглан давтаарай:

AHS-н технологийн бүлгүүдээр дамжуулан та Wi-Fi-д холбогдох, харилцагчид нэмэх, google орчуулагч ашиглах гэх мэт өдөр тутмын амьдрал, эрүүл мэндээ сайжруулахад туслах ухаалаг утасны үндсэн функцуудыг сурах ёстой!
(510)-735-3222 дугаар луу залган дараагийн бүлэгт бүртгүүлнэ үү.

Аливаа гамшиг ослын тохиолдолд бэлэн байгтун!

*Хэдхэн хялбар алхам хийснээр та гэнэтийн
тохиолдолд өөрийгөө болон хайртай хүмүүсээ аюулаас
аврах боломжтой.*

1. Гамшгийн сэрэмжлүүлэгт бүртгүүлнэ үү:

CalAlerts.org хаягаар орж шинэчлэлтүүдийг хүлээн авна уу / MyShake програмыг татаж авна уу / Нүүлгэн шилжүүлэх зам, түр орогнох байрын талаарх мэдээллийг 211 рүү залгаж эсвэл мессеж бичин авна үү

2. Төлөвлөгөө гарга! Холбоо барих жагсаалт (гэр бүл, найз нөхөд гэх мэт), орон нутгийн туслах байгууллагуудан лавлах (галын алба, цагдаа, цахилгаан, хий гэх мэт) үүсгэж, нүүн шилжих маршрутаа төлөвлө.

3. Хэрвээ та гэрээсээ яаралтай нүүн шилжих шаардлагатай бол хэрэгтэй зүйлээ GO ЦҮНХ-дээ хийж бэлэн болгоорой.

4. Гэртээ цахилгаан, усгүй амьдрахаас өөр аргагүй болсон бол STAY BOX хий. (Сав баглаа боодлын нарийвчилсан хяналтын хуудсыг линкээр орж үзнэ үү)

5. Ойр хавийнхаа хүмүүстэйгээ яриа өрнүүлж, бусдад бэлтгэлтэй байхад нь тусал.

(Дэлгэрэнгүй мэдээллийг QR кодыг уншина уу)




Хэт халуун агаартай байх үед ус сайн уу:

Ус сайн уу, нарны тос түрхэж, сүүдэрт бай, сул, хөнгөн хувцас өмсөж, өдрийн ид халуун үеэр дасгал бүү хий, аль болох агааржуулалттай орчин бай, 65-аас дааш насны, халуун агаар аюултай байж болох хүмүүст санаа тавиарай

(ListosCalifornia.org/resources хуудсанд зочилж тайваан байх талаарх бусад зөвлөгөөг авна уу)

MyChart өвчтөний порталыг



2023 оны 11-р сард Азийн Эрүүл Мэндийн үйлчилгээ MyChart өвчтөний порталыг ажиллуулж эхэлснээр хэрэглэгчдээс эерэг санал аваад байна. Та үүнийг ашигласнаар үзлэгийн цаг товлох, шинжилгээний хариу шалгах, эм авах зэрэг эрүүл мэндийн үйлчилгээг онлайнаар авах боломжтой. Энэ портал нь хэрэглэхэд хялбар, та бүхний хэрэгцээнд нийцсэн тул та өөрийн эрүүл мэндэд хяналт тавих боломжийг олгож байна. Хэрэв та хараахан бүртгүүлж амжаагүй байгаа бол доорхи зүйлсийг хийнэ үү:

- Хэрэв та MyChart-ийг шинээр ашиглах гэж байгаа бол эмнэлэгт очихдоо ажилтнуудаас идэвхжүүлэх код асуугаарай. Эсвэл та цахим хаягаа ашиглан онлайнаар бүртгүүлж болно.
- Идэвхжүүлэх код авсаны дараа MyChart вэб сайт руу орох эсвэл апп татаж аваад бүртгэлээ үүсгээрэй. Идэвхжүүлэх кодоо оруулаад бүртгэлийн үйл явцыг дуусгахын тулд зааврыг дагана уу.
- Одоо та MyChart-ын санал болгож буй бүх зүйлийг судлахад бэлэн боллоо!

Эрүүл мэндийн асуудлаа шийдэж, эмнэлгийн багтайгаа холбоотой байхын тулд энэхүү порталын үйл ажиллагаа, функцуудтай сайтар танилцаарай. MyChart-д бүртгүүлж эрүүл мэндийн тусламж үйлчилгээний оновчтой менежментийн ашиг тусыг өөрийн биеэр мэдрээрэй!

Энэ нь зөвхөн өвчтөний порталаас илүүтаны тав тухтай, хүртээмжтэй эрүүл мэндийн тусламж үйлчилгээний гарц юм.

2024 оны 11-р сарын 5-нд та эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг хамгаалах болон өргөжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор Азийн Эрүүл Мэндийн Үйлчилгээг дэмжих боломжтой!

2024 оны 11-р сарын 5-нд та эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг хамгаалах болон өргөжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор Азийн Эрүүл Мэндийн Үйлчилгээг дэмжих боломжтой! Иймд 2024 оны Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг хамгаалах тухай хуулийн 35-р зүйлд ТИЙМ хэмээн саналаа өгнө үү. Уг 35-р заалт нь эрүүл мэндийн даатгалын компаниудад ногдуулах татварыг сунгах замаар эрүүл мэндийн чухал тусламж үйлчилгээний байнгын орлогыг баталгаажуулж, хувь хүмүүсийн татварыг нэмэгдүүлэхгүйгээр эдгээр орлогыг ашиглан Калифорниачууд болон Азийн Эрүүл Мэндийн Үйлчилгээний Үйлчилгээ болон түүний үйлчлүүлэгчдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хамгаалах өргөжүүлэх тухай юм



2024 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ – ЭРҮҮЛ МЭНДИЙНХЭЭ ТӨЛӨӨ САНАЛАА ӨГЧ БАЙНА.

Санал өгөх нь чухал! Энэ нь таны болон бидний эрүүл мэнд, аж амьдралд бичухал ач холбогдолтой. 2024 оны 11-р сарын 5-нд АНУ-ын иргэн, 18-аас доошгүй насны хүмүүс санал өгөх эрхтэй. Манай хот, муж, улс, холбооны гүйцэтгэх засаглалыг хэн удирдах зэргийг шийдэх манай нийгэмлэгийн асуудал нилээдгүй байна. Энэ жил бид бас дараагийн Ерөнхийлөгчөө сонгох болно.

Сонгууль юунд нөлөөлж болох вэ?

Хотын зөвлөлийн гишүүн, мужийн Хяналтын Зөвлөл, хотын дарга зэрэг албан тушаалтнуудад санал өгөхдөө сургуулийн санхүүжилт, хямд орон сууц, сэтгэцийн эрүүл мэнд, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ зэрэг асуудлаа шийдэх сонголт хийж байна.

Ази гаралтай Америкчууд мэдэгдэхүйц өссөнөөр, санал өгөх эрх мэдэлтэй болсон. 2020 онд ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр сонгогчдын ирц 2016 онтой харьцуулахад 15%-иар буюу 2 сая орчим сонгогчийн ирцээр Ази гаралтай америкчууд хамгийн их өссөн байна. Хэрэв сонгууль өгөх эрхтэй бүх хүмүүс саналаа өгвөл бол уг хүн ам үнэхээр сонгуульд нөлөөлнө.

Санал өгөхийн тулд Калифорни мужид бүртгэлтэй сонгогчид 11-р сарын 5-нд болох ерөнхий сонгуулийн саналын хуудсыг шуудангаар хүлээн авна:

- Танай мужийн Сонгуулийн Хороо 2024 оны 10 дугаар сарын 07-ны дотор саналын хуудсыг шуудангаар илгээнэ.
- Энэ удаагийн ээлжит сонгуульд санал өгөхөөр бүртгүүлэх сүүлийн өдөр нь 2024 оны аравдугаар сарын 21.
- Саналын хуудсыг солих хүсэлтийн эцсийн хугацаа 2024 оны 10-р сарын 29 хүртэл.



Санал Өгөх Бүртгэлтэнд Тавигдах Шаардлага

Калифорнид санал өгөхөөр бүртгүүлэхийн тулд та:

- АНУ-ын иргэн, Калифорнийн оршин суугч (цэргийн болон гадаадад байгаа сонгогчдын талаарх мэдээллийг авах бол QR код #1 уншина уу)
- Сонгуулийн өдөр 18 ба түүнээс дээш насны
- Таны амьдарч буй газарт бүртгүүлсэн
- Одоогоор мужийн болон холбооны хорих ангид ял эдлээгүй байна (QR код #2)
- Шүүхээс санал өгөх сэтгэцийн чадваргүй гэж тогтоогдоогүй (QR код #3)

Калифорнийн сонгогчдын онлайн бүртгэл: (QR код #4)



#1



#2



#3



#4

Калифорнийн Сонгогчдын Онлайн Бүртгэл

<https://registertovote.ca.gov/>. Сонгогчдын Онлайн Бүртгэл нь Англи хэлнээс гадна 9 хэлээр хийгдэнэ.: Хятад, Хинду, Япон, Кашмер, Солонгос, Испани, Тагалог, Тайланд, Вьетнам.

Онлайнаар бүртгүүлэхийн тулд танд хэрэгтэй болох зүйлс:

- Таны Калифорнийн жолооны үнэмлэх эсвэл Калифорнийн иргэний үнэмлэхний дугаар
- Нийгмийн даатгалын дугаарын сүүлийн дөрвөн орон; болон
- Таны төрсөн огноо.

Таньд Асуух Асуулт байна уу эсвэл Залилангийн талаар Мэдээлэхийг хүсч байвал?

Төрийн Нарийн Бичгийн Даргын Сонгогчдын лавлах утас руу (800) 345-VOTE(8683) or <https://www.sos.ca.gov/elections/voting-resources/county-elections-offices>.

АНС ӨВЧТӨНИЙ ЕРӨНХИЙ ХУРАЛ 2024

October 30th, 2024: 9:00 AM to 12:00 Noon

Oakland Asian Cultural Center (388 9th St Ste 290, Oakland, CA 94607)

Хэрэв та элсэх сонирхолтой бол (510)735-3222 утсаар холбогдоно уу

